



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
З.ЭНХБОЛД ТАНАА

2014.02.28 № 284
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 63 дугаар тогтоолоор өгөгдсөн үүргийн дагуу Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд "0.0" дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн, гүйцэтгэл удааширсан шалтгааныг тогтоох, гүйцэтгэл, хэрэгжилтийн явц байдалд хийсэн дүн шинжилгээний аудитын тайланг хүргүүлж байна.

Танилцаж, холбогдох арга хэмжээ авна уу.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070097



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улсын Их Хурлын 2013 оны 63 дугаар тогтоолын дагуу
гүйцэтгэсэн ажлын тайлан

**МОНГОЛ УЛСЫН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД “0.0”
ДҮНТЭЙ ТУСГАГДСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ НЭМЭГДСЭН, ГҮЙЦЭТГЭЛ
УДААШИРСАН ШАЛТГААНЫГ ТОГТООХ, ГҮЙЦЭТГЭЛ,
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ БАЙДАЛД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ**

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:			
	Товчилсон үгийн тайлбар		3
Үндэсний аудитын газар	Дүн шинжилгээний аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй		4
<ul style="list-style-type: none"> ▪ Гүйцэтгэлийн аудитын газар ▪ Нийцлийн аудитын газар ▪ Аймаг, нийслэлийн аудитын газар 	<ul style="list-style-type: none"> ▪ Үндсэн мэдээлэл ▪ Зураг, төсөв, техникийн нөхцөл, газрын зөвшөөрөлгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна..... ▪ Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж чадахгүй байна..... ▪ Захиалагч гэрээний хэрэгжилт, барилга угсралтын ажилд хяналт тавьж чадахгүй байна..... ▪ Гүйцэтгэгчийн санхүүгийн болон хүний нөөц, ажлын хариуцлага хангалтгүй байна..... ▪ Барилга байгууламжийн байршил, хийц, талбайн хэмжээнээс шалтгаалан төсөвт өртөг харилцан адилгүй байна ▪ Барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэл санхүүжилтээс зөрүүтэй байна..... ▪ Барилгын төсөв зохиох норм, норматив, барилгын үнэ бүрдэлтийн журмыг 2012 онд өөрчилж шинэчилсэн нь барилгын төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байна..... 		5 6 10 11 12 13 14 15
2014 оны 2 дугаар сар			
Уг тайланг УАГ-ын Веб сайт-аас үзнэ үү.			
www.mnao.mn			
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263806, 261675 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу			
ХАЯГ:	Дүгнэлт санал		19
Үндэсний аудитын газар Засгийн газрын IV байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс	Нэг. Дүн шинжилгээнд хамрагдсан төсөл, арга хэмжээг цаашид хэрэгжүүлэх талаар		19
	Хоёр. Гүйцэтгэл удааширсан, төсөвт өртөг нэмэгдсэн шалтгаан, цаашид авах арга хэмжээний талаар		20
	ХАВСРАЛТУУД:		22

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
БУА	Барилга угсралтын ажил
БЗА	Барилга захиалагчийн алба
БЗД	Баянзүрх дүүрэг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗТБХБС	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд
ЗТС	Зам, тээврийн сайд
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ХЗС	Хууль зүйн сайд
СЯ	Сангийн яам
ССАЖС	Соёл, спорт, аялал жуулчлалын сайд
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТНЖБТХ	Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль
ҮХААС	Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар
СБД	Сүхбаатар дүүрэг
ХС	Хөдөлмөрийн сайд
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ЭЗХС	Эдийн засгийн хөгжлийн сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШС	Шадар сайд
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль

ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Дүн шинжилгээ хийсэн үндэслэл

“Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 63 дугаар тогтоолоор өгөгдсөн үүрэг, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд энэхүү дүн шинжилгээний ажлыг хийлээ.

2. Дүн шинжилгээний ажлын зорилт

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “0.0” дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн, гүйцэтгэл удааширсан шалтгаан нөхцлийг нарийвчлан тогтоох, гүйцэтгэл, хэрэгжилтийн явц байдалд дүн шинжилгээ хийх, цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт гаргаж УИХ-д танилцуулахад дүн шинжилгээний ажлын зорилт чиглэгдэв.

Дүн шинжилгээний ажлыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ.Үүнд:

- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “0.0” дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нэмэгдсэн шалтгааныг нарийвчлан судалж тогтоох.
- Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд “0.0” дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удааширсан шалтгааныг нарийвчлан судалж тогтоох.

3. Хамарсан хүрээ

Энэ аудитад СЯ, ХЗЯ, БХБЯ, БХЯ, БШУЯ, ЗТЯ, ССАЖЯ, ҮХААЯ, ХАХНХЯ, ЭМЯ зэрэг яам, зарим агентлаг, газар, төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч байгууллагууд хамрагдлаа. 21 аймаг, нийслэл, 9 дүүрэг, 130 сумын нутаг дэвсгэрт баригдаж буй барилга байгууламж, зам гүүр, тоног төхөөрөмж, их засварын 272 төсөл, арга хэмжээг шалгаж, бодит гүйцэтгэлд дүн шинжилгээ хийлээ.

4. Арга зүй

Дүн шинжилгээнд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглахын зэрэгцээ захиалагч байгууллагуудын улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт материалд судалгаа хийн хариуцсан албан тушаалтантай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга авч, гүйцэтгэгч байгууллагын тайлан, ажлын гүйцэтгэлийн баримт материалд тулгуурлан баталгаажуулалт хийж, үнэлэлт дүгнэлт өглөө.

Аудитад мэргэжлийн шинжээчээр ШУТИС-ийн доктор, зөвлөх инженер Я.Дүйнхэржав, доктор, зөвлөх инженер З.Биндэрьяа, барилгын мэргэшсэн төсөвчид, инженер техникийн ажилтнуудыг оролцуулав.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, барилга байгууламжийн гүйцэтгэл, төсөвт өртгийг хянасан дүгнэлт, объект тус бүрийн хувийн хэрэг, хавсралт судалгааг цахим болон биетээр хэлбэрээр ажлын баримт материалд хавсаргав.

Үндсэн мэдээлэл

1.1 Улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад “0.0” дүнтэй тусгагдсан хөрөнгө оруулалтын 243 төсөл, арга хэмжээг хариуцсан төсвийн ерөнхийлөн захирагчдаар авч үзвэл дараах байдалтай байна.

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний тоо	Дэд арга хэмжээний тоо	Төсөл, арга хэмжээний тоонд эзлэх хувь	Нийт төсөвт өртөг	Хүснэгт №1
						Төсөвт өртөгт эзлэх хувь
1	БШУС	126	7	48.9	156 092.1	20.5
2	ССАЖС	39	-	14.3	79 953.5	10.5
3	БХБС	24	20	16.2	123 936.4	16.2
4	ЗТС	18	-	6.6	265 849.5	34.8
5	ЭМС	10	-	3.7	54 125.0	7.1
6	ХЗС	5	-	1.8	43 402.0	5.7
7	ҮХААС	4	-	1.5	3 500.0	0.5
8	ХС	4	-	1.5	2 523.3	0.3
9	СС	4	2	2.2	12 950.0	1.7
10	ШС	4	-	1.5	4 238.0	0.6
11	ХАХНХС	3	-	1.1	4 691.0	0.6
12	БХС	1	-	0.4	1 750.0	0.2
13	БОНХС	1	-	0.4	10 000.0	1.3
Нийт дүн		243	29	100	763 010.8	100

1.2 Дээрх төсөл, арга хэмжээг байршлаар нь үзүүлбэл:

ТЕЗ	Нийслэлд		Аймгийн төвд		Суманд	
	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг
	<i>(тоо, сая төгрөг)</i>					
БШУС	20	29 602.2	36	54 944.8	77	71 545.1
ССАЖС	2	22 492.0	15	39 716.9	22	17 744.6
БХБС	10	49 032.7	25	38 875.7	9	36 028.0
ЗТС	3	33 625.0	8	170 426.0	7	61 798.5
ЭМС	4	45 504.6	4	7 918.9	2	701.5
ХЗС	4	43 402.0	1	-	-	-
ҮХААС	3	1 500.0	1	2 000.0	-	-
ХС	-	-	3	2 253.3	1	270.0
СС	-	-	-	-	6	12 950.0
ШС	2	2 420.0	-	-	2	1 818.0
ХАХНХС	-	-	3	4 691.0	-	-
БХС	1	1 750.0	-	-	-	-
БОНХС	1	10 000.0	-	-	-	-
Бүгд	50	239 328.5	96	320 826.6	126	202 855.7

1.3 Төсөл, арга хэмжээг зориулалтаар нь төрөлжүүлж харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №3

Төсөл, арга хэмжээ бүгд	Сургуулийн барилга, өргөтгөл	Цэцэрлэгийн барилга, өргөтгөл	Соёлын төв	Спорт цогцолбор, спорт заал	Дотуур байр	Цэвэр, бохир усны шугам	Авто зам, замын өргөтгөл	Театр, урлагийн заал, цэцэрлэгт хүрээлэн	Эмнэлэг, төрөх эмнэлэг	Бусад
272	51	52	21	20	17	19	12	9	10	61
100	18.8	19.1	7.7	7.4	6.2	7.0	4.4	3.3	3.7	22.4

1.4 Дээрх төсөл, арга хэмжээнээс ажил нь дууссан 26, 90-ээс дээш хувийн гүйцэтгэлтэй 6, эхлээгүй 99, үргэлжилж байгаа 141 байна.

1.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эдгээр 272 төсөл, арга хэмжээг эхэлсэн хугацаагаар ангилж харуулбал дараах байдалтай байна:

Хүснэгт №4

№	ТЭЗ	Төсөл, арга хэмжээний тоо	2008	2009	2010	2011	2012	2013	2014
1	БШУС	133	2	2	1	11	74	41	2
2	ССАЖС	39	2	-	2	6	28	1	
3	БХБС	44	1	-	1	6	11	24	1
4	ЗТС	18	1	-	-	2	7	8	
5	ЭМС	10	-	-	1	4	2	3	
6	ХЗС	5	-	1	-	-	1	2	1
7	ҮХААС	4	-	-	-	-	3	1	
8	ХС	4	-	-	-	-	1	3	
9	СС	6	-	-	-	-	1	5	
10	ШС	4	1	-	2	1	-	-	
11	ХАХНХС	3	-	-	-	-	1	2	
12	БХС	1	-	-	-	-	1	-	
13	БОНХС	1	-	-	-	-	1	-	
Нийт дүн		272	7	3	7	30	131	90	4

1.6 Судалгаанаас үзэхэд 3-6 жил үргэлжилж байгаа 47 объект байгаагийн дийлэнх нь БШУС, БХБС, ЭМС, ЗТС, ССАЖС-ын багцад хамаарч байна.

Зураг, төсөв, техникийн нөхцөл, газрын зөвшөөрөлгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна

1.7 Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад дараах хууль, тогтоомжийн заалтууд зөрчигдсөн байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 29.4-ийн "Хөрөнгө оруулалтын төсөвт ТЭЗҮ хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хууль заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана",
- Барилгын тухай хуулийн 15.2-ын "Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахыг хориглоно",
- Иргэний хуулийн 350.1.1-ийн "Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ",

- ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”,
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.8-ын Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн 1 дүгээр сарын 15-ны дотор эхлүүлэх,
- Барилгын тухай хуулийн 13.2-ийн “... улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, ... магадлал заавал хийлгэнэ,
- 13.5-ын “... зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиолдолд барилгын ажил эхлэхийг хориглоно,
- 15.1.1-ийн “Барилга байгууламж барих, газрын зөвшөөрөл авах, техникийн нөхцөл бүрдүүлэх, зураг, төсөл, захиалах,
- 15.1.2-ын “Барилгын ажлын явц, чанарт хяналт тавих, фото зургаар баримтжуулсан ил, далд ажлын актыг баталгаажуулах,
- 15.1.6-ын “Барилгын зураг, төсөл, барилгын ажилд хөндлөнгийн хяналт хийлгэх”,
- 17.1.3-ын “... барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих гэх мэт заалт зөрчигдөж байна.

1.8 Дээрх хуулийн заалтуудыг зөрчсөн байдлыг ТЕЗ-даар харуулбал:

Хүснэгт №5

ТЕЗ	Нийт арга хэмжээ	Төсвийн тухай хуулийн 29.4, (СС-ын 2010 оны 135 дугаар тушаалаар баталсан журам)	Барилгын тухай хуулийн 15.2	Иргэний хууль 350.1.1	Барилгын тухай хууль			ТБОНӨХБАҮХАТХ	
					13.2	13.5	17.1.3	8.4	46.1.8
БШУС	133	104	104	45	14	23	20	39	18
ССАЖС	39	36	35	13	5	1	7	18	4
БХБС	44	18	19	15	9	10	8	4	2
ЗТС	18	11	9	6	3	7	1	-	-
ЭМС	10	8	4	3	1	2	-	3	1
ХЗС	5	3	3	-	-	-	-	-	-
ҮХААС	4	1	2	-	-	-	-	2	1
ХС	4	3	2	-	1	2	-	1	-
СС	6	4	1	1	1	1	2	-	-
ШС	4	3	-	-	1	1	1	-	-
ХАХНХС	3	3	2	-	1	2	-	-	-
БХС	1	1	1	-	-	-	-	-	-
БОНХС	1	1	1	-	-	-	-	-	-
Нийт	272	196	196	83	36	49	39	67	26

1.9 Дүн шинжилгээнд хамрагдсан 272 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад хууль, тогтоомж, журмын 51 заалт нийтлэг байдлаар зөрчигдсөн ба давхардсан тоогоор 1034 зөрчил бүртгэгдлээ.

1.10 Төсвийн тухай хуулийн 29.4, Барилгын тухай хуулийн 15.2 дахь заалтыг зөрчиж, зураг, төсөл нь бэлэн болоогүй нийт 196 төсөл, арга хэмжээг төсвийн тухай хуулийн улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгаж баталсан нь дээрх 272 объектын дийлэнх буюу 72.1 хувийг эзэлж байна.

1.11 Гүйцэтгэх хугацаа нь удааширч 3-6 жил үргэлжилж байгаа 47 төсөл, арга хэмжээний 13 нь зураг төсөвгүйгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан байна.

1.12 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад зураг төсөвгүй батлагдсан 196 төсөл, арга хэмжээний 18 нь одоо болтол баталгаажсан зураг төсөвгүй байна.

1.13 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад зураг төсөвгүйгээр батлагдсан объектоос магадлалын ерөнхий дүгнэлттэй төсөл, арга хэмжээг судалж үзэхэд зураг төсвийг боловсруулж, баталгаажуулахад 3 сар хүртэл 7, 3-6 сар хүртэл 27, 6-12 сар хүртэл 75, нэг жилээс дээш хугацаа зарцуулсан 53 төсөл, арга хэмжээ байна.

1.14 Барилгын ажлын явц, чанарт хяналт тавих, гүйцэтгэлийг баталгаажуулах, барилгын зураг, төсөл, барилгын ажилд хөндлөнгийн хяналт тавих, баталгаат хугацаанд илэрсэн зөрчлийг арилгуулах зэрэг хяналтын чиг үүргээ захиалагч байгууллагууд хангалтгүй хэрэгжүүлсэн дутагдал бүх объект дээр нийтлэг байгаагийн дээр Барилгын тухай хуулийн 15.1.2, 15.1.6, 15.1.7 дах заалтыг зөрчсөн тохиолдол хэрэгжиж буй объектын 32.7 хувьд бүртгэгдсэн байна.

1.15 Хуульд нэр, байршил, хүчин чадал, ажлын тоо хэмжээг буруу тусгаснаас хэрэгжих боломжгүй болсон дараах тохиолдол гарсан байна:

- Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын 150 хүүхдийн дотуур байрны барилгын ажлыг Хөвсгөл аймгийн Ханх суманд гэж,
- Дундговь аймгийн ШШГА-ны нэг цэгийн үйлчилгээтэй нэгдсэн контор, цагдан хорих байрыг Өмнөговь аймагт гэж,
- Төв аймгийн Баяндэлгэр сумын соёлын төвийн барилга (250 суудал) нэрээр төсвийн тухай хуульд тусгагдсан боловч, зураг төсөв нь соёлын төвийн засвар, уурын зуух шинээр барих, өргөтгөл хийх гэж тус тус батлагдсан,
- Сэлэнгэ аймгийн авто замын шинэчлэл нэрээр 500.0 сая төгрөгийг 2014 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь хийгдсэн ажилд хөрөнгө төсөвлөсөн.
- Түүнчлэн Хөвсгөл аймгийн гаальчдын 8 айлын орон сууц (Хөвсгөл аймгийн Мөрөн сум) гэсэн нэрээр төсвийн тухай хуульд тусгагдсан объект бодит байдалд Хөвсгөл аймгийн Ханх суманд барихаар төлөвлөсөн баригдаж байна.

1.16 Хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлоогүй, тухайн орон нутгийн хүн амын тоо, хүчин чадалтай уялдаагүй, ашиглалтын үед гарах зардал, санхүүжилтийг тооцоолоогүй дараах төсөл, арга хэмжээ байна:

- Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Рашаант тосгонд 250 суудалтай соёлын төв, 15 албан хаагч байрлах конторын барилгын төсөвт өртөг 1,383.7 сая төгрөг байна. Цаашид энэ өртгийг өсгөхөөр санал өгсөн,
- Дорнод аймгийн Баянтүмэн сум нь аймгийн төвөөс 10 км зайд оршдог бөгөөд 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй урлаг спортын цогцолбор баригдсан,
- Булган аймгийн Булган суманд баригдаж буй 640 суудалтай сургуулийн барилга нь анх 520 суудалтай батлагдсан ч орон нутгийн санаачлага, БШУЯ-ны хүсэлтээр суудлын тоог нэмэгдүүлсэн ч зураг нь гараагүй, шинээр төсөв боловсруулсан,
- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Дэнж багт баригдаж буй 250 суудалтай соёлын

төвийн барилгын ажлын төсөвт өртөг нэмэгдсэн ч захиалагчаас баталгаажуулж, гэрээг шинэчлээгүй,

- Дорнод аймгийн Хэрлэн сумын 2 дугаар багт баригдаж буй спортын цогцолбор гэх мэт.

1.17 Барилгын тухай хуулийн 15.1.1 дэх заалтыг зөрчиж барилгын инженерийн гадна шугам сүлжээ, техникийн нөхцлийг бүрэн шийдвэрлээгүй барилга байгууламжийг төсөвт тусгасан, барилгын ажлыг эхлүүлсэн, улмаар гүйцэтгэл удааширч, төсөвт өртөг нэмэгдэж ашиглалтад орох хугацаа тодорхойгүй болсон объектууд байна. Тухайлбал, нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж буй 300 ортой төрөх эмнэлэг, Геронтологийн төв, Үндэсний төв архивын нэгдсэн байрны барилгын ажлыг 2010-2011 онд эхэлсэн боловч инженерийн байгууламжийн техникийн нөхцөл 2014 онд ч шийдвэрлэгдэхээргүй байна.

1.18 Мөн зарим төсөл, арга хэмжээнд барилга барих газрын зөвшөөрөлгүй болон гэрчилгээг давхардуулан олгосон, газрын маргаан үүссэнээс шалтгаалан хэрэгжих хугацаа нь удааширсан, төсөвт өртөг нэмэгдсэн тохиолдол гарсан байна. Тухайлбал,

- Сонгинохайрхан дүүргийн 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын газар олголт айлын газартай давхардсанаас байршил өөрчлөгдөн зураг төсөвт өөрчлөлт орж, 390.0 сая төгрөгийн нэмэлт ажлын гэрээ байгуулсан,
- Баянзүрх дүүргийн 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга баригдах газар нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад төсөвт тусгаснаас газрын маргаан үүссэн,
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын дунд сургуулийн спорт заалны барилга барих газар нь автомашины гарааш, айлын газар, байгууллагын эзэмшил газартай хэсэгчилсэн байдлаар давхардсан,
- Архангай аймгийн Хангай сумын 320 суудалтай сургуулийн барилга барих талбай нь иргэдэд олгосон газартай давхардсан,
- Булган аймгийн Булган сумын 150 ортой цэцэрлэгийн барилга 2012 оны төсөвт тусгагдсан ч газрын маргаан гарч ажил оройтож эхэлсэн гэх мэт.

1.19 Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.8-д “магадлал хийх иргэн, хуулийн этгээдийг өрсөлдөөний журмаар сонгох” заалтын дагуу сонгон шалгаруулатад оролцож эрх аваагүй “Эм Си Си корпорейшн” ХХК нэр бүхий 9 барилга байгууламжид магадлал хийсэн байна.

Хүснэгт №6

№	Хуульд	Төсөл, арга хэмжээний нэр	ТЭЗ	Төсөвт өртөг, сая төгрөг	Баталгаажуулсан огноо	Төсөвт магадлал хийсэн төсөвчний нэр
1	XVII.1.1.35	Сургуулийн барилгын өргөтгөл /Ховд, Чандмань сум/	БШУС	1,241.8	2012.06.20	Ж.Лхагвасүрэн
2	XVII.1.1.96	Сургуулийн спорт заалны барилга /Хөвсгөл, Мөрөн, 2 дугаар сургууль/	БШУС	1,015.3	2013.05.09	МССС корпораци
3	XVII.1.1.134	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Архангай, Эрдэнэмандал сум/	БШУС	4,661.7	2013.05.02	Ж.Цээлээ
4	XVII.1.1.136	Сургуулийн барилга, 640 суудал, /Дорнод, Баян-Уул сум/	БШУС	1,990.0	2013.04.26	Ж.Зундуй

5	XVII.1.1.145	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Цагаанчулуут сум/	БШУС	952.1	2013.05.23	Ж.Зундуй
6	XVII.1.1.158	Сургуулийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Хархорин, Эрдэнэ-Зуу, Шашны сургууль/	БШУС	1,841.7	2012.10.23	МССС корпораци
7	XIX.1.1.4	Аймгийн хөгжимт драмын театрын барилга /Архангай/	ССАЖС	9,948.3	2012.11.12	А.Эрдэнэчимэг
8	XIX.1.1.12	Хан-Хэнтий чуулгын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	ССАЖС	8,353.7	2012.05.02	Ж.Лхагвасүрэн
9	XIX.1.1.26	Соёлын төвийн барилга, 250 суудал /Төв, Баяндэлгэр сум/	ССАЖС	443.9	2013.05.03	А.Эрдэнэчимэг
ДҮН				30,448.5		

Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж чадахгүй байна

1.20 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулсан журмыг хэрхэн сонгосныг доорхи хүснэгтэд харуулав.

Үзүүлэлт	Төсөл арга хэмжээний тоо	НТШ	Шууд гэрээ	ХТШ	Тендер зарлаагүй
Тоо	272	180	16	6	70
Хувь	100	66.2	5.9	2.2	25.7

1.21 Түүнчлэн төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад зарцуулсан /тухайн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан өдрөөс, гэрээ байгуулах зөвлөмж өгсөн/ хугацаанд судалгаа хийж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №7

ТЭЗ-ийн нэрийн товчлол	Төсөл арга хэмжээ	Зарцуулсан хоног, үүнээс					Тендер зарлаагүй
		1-30	31-60	61-90	91-180	181-ээс дээш	
Тоо	272	10	31	33	65	63	70
Хувь	100	3.7	11.4	12.1	23.6	23.2	25.7

1.22 Захиалагч ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно” гэснийг зөрчиж, иж бүрнээр нь бус хэсэгчилсэн байдлаар тендер зарлах, төсвийн тухай хуульд ажил эхлүүлэх байдлаар тусгуулсан бага өртөг, тухайн жилийн төсвийн хуульд батлагдсан санхүүжилтийн дүнгээр гэрээ байгуулсан тохиолдол 67 объектод гарсан байна.

1.23 Дээрх тохиолдол бүрт анх батлагдсан төсөвт өртөг нэмэгдсэн байна. Тухайлбал,

- ССАЖЯ-наас Гандантэгчилэн хийдийн өргөтгөлийн барилга (1080 суудал)-ын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг тухайн жилийн төсөвт батлагдсан дүнтэй уялдуулан 5 удаа тендер зарласан ба анх батлагдсан төсөвт өртөг 5.2 дахин буюу 12,892.0 сая төгрөг болж өссөн,
- Геронотологийн эмнэлгийн үндсэн барилгын зарим хэсгийг үлдээж тендер зарлан

гэрээ байгуулснаас гүйцэтгэл 3-4 жил үргэлжилсэн ба уг барилга нь 4 блоктор, анхны төсөвт өртөг нь 4,724.6 сая төгрөгөөр экспертизээр баталгаажсан,

- Алтай чуулгын барилгыг зураг төсөвгүйгээр 2007 оны төсвийн тухай хуульд 1,000.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд хэсэгчилсэн зураг, төсвийг 3 удаа баталгаажуулан тухай бүрд нь тендер зарлан төсөвт өртөг 6,295.9 сая төгрөг болсон гэх мэт.

1.24 Баталгаажуулсан зураг төсөвгүй, ажлын тоо хэмжээг бууруулан тендер зарлаж буй тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал,

- Дорноговь аймгийн Айраг сумын Аврах гал унтраах ангийн барилга,
- Улаанбаатар хотын Хог боловсруулах үйлдвэр,
- Сэлэнгэ аймгийн Түшиг сумын үйлчилгээний төвийн барилга,
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын үйлчилгээний төвийн барилга,
- Ховд аймгийн Жаргалант сумын цэвэр усны шугам, өргөлтийн станцын шинэчлэл,
- Дорноговь аймагт хэрэгжиж буй "Шинэ сум" төсөл гэх мэт.

Захиалагч гэрээний хэрэгжилт, барилга угсралтын ажилд хяналт тавьж чадахгүй байна

1.25 Иргэний хуулийн 350.1.1 дэх заалтыг зөрчиж, гэрээнд заасан хугацаанд барилга объектыг ашиглалтад өгөөгүй 83 гүйцэтгэгч байгаа бөгөөд тэдгээр нь доорхи ТЕЗ-дын багцад хамаарч байна. Үүнд:

- БШУС-ын багцад 45,
- Сангийн сайдын багцад 1,
- ЭМС-ын багцад 3,
- Зам, тээврийн сайдын багцад 6,
- ССАЖС-ын багцад 13,
- БХБС-ын багцын 15 төсөл, арга хэмжээ байна.

1.26 Захиалагч зургийн даалгаврыг иж бүрэн боловсруулаагүй, барилга угсралтын үе шатны ажилд хяналт тавьж чадаагүй, нэмэлт ажил захиалснаас төсөвт өртөг нэмэгдсэн, үргэлжлүүлэх боломжгүй барилга байгууламжууд байна. Тухайлбал,

- Дархан-Уул аймгийн Дархан суманд 2200 суудалтай спорт цогцолбор 2011 онд 11,052.9-сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдаж байсан бол 2013 онд 21,495.9 сая төгрөг болж өссөн байна. Энэ нь ажлын зураг тусгагдаагүй ажлууд нэмэгдсэн ба тэдгээрийн дотор зураг төсөвт гаднах инженерийн шугам сүлжээ, тохижилтын ажил, зарим тоног төхөөрөмжийг тусгаагүй, барилгын хийц өөрчлөгдсөн, нэг блок барилгын гадна ханын өөрчлөлт хийсэн учир нэмэлт ажлын зураг хийснээр нийт ажлын төсөвт өртөг 10,443.0 сая төгрөгөөр нэмэгдэхээр болсон,
- Завхан аймгийн Улиастай сумын Хөгжимт жүжгийн театрын барилгын инженер геологийн дүгнэлтийг "Гурван тэс" компани гаргахдаа 3.5 метрийн гүнд хөрсний ус илэрсэн гэж тусгасан боловч, суурийн ажил эхлэх үед хөрсний ус 1.5 метрээс гарсан,
- Хөвсгөл аймгийн цэвэрлэх байгууламжийн технологи хоцрогдсон, аймгийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэ суурьшлын бүсэд 100 м ойрхон учраас үргэлжүүлэх шаардлагагүй болсон,
- Ховд аймгийн төвийн цэвэр усны шугам, өргөлтийн станцын шинэчлэлийн төсөл

арга хэмжээний гүйцэтгэгч Хүчит чулуу ХХК гэрээний хугацаанд ажлаа дуусаагүй, гэрээг 3 удаа хугацаа сунгасан, цутгасан усан сангийн хананд цууралт үүссэн, чанаргүй гүйцэтгэлтэй,

- Дорнод аймгийн төвийн усан бассейныг 1990-ээд оны хуучин барилгын суурин дээр байгуулахаар төлөвлөсөн боловч барилгын төмөр хийц технологийн шаардлага хангахгүйгээс барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон гэх мэт.

Гүйцэтгэгчийн санхүүгийн болон хүний нөөц, ажлын хариуцлага хангалтгүй байна

1.27 Гүйцэтгэгчид барилга угсралтын ажлын технологийн горим зөрчсөн, батлагдсан зураг төсвийн дагуу ажлаа гүйцэтгээгүй, үе шатны ажлаа баримтжуулаагүй тохиолдол байна. Тухайлбал,

- Хэнтий аймгийн Биндэр сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын сууринд ан цав гарсан тул нэмэлт ажил хийх шинжээчийн дүгнэлт гарсан,
- Сүхбаатар аймгийн 700 суудалтай спорт цогцолборын барилгыг барих явцад технологийн горим зөрчиж, хучилтыг хөлдөөснөөс барилга угсралтын ажлыг зогсоох дүгнэлтийг мэргэжлийн хяналтын газраас гаргасан,
- Хэнтий аймгийн Хан Хэнтий чуулгын барилгыг зургийн дагуу хийгээгүйгээс чанарын шаардлага хангаагүй гэсэн шинжээчийн дүгнэлт гарсан,
- Сэлэнгэ аймгийн Ерөө сумын үйлчилгээний төвийн барилгын суурийн цутгалтын чанар хангалтгүй, арматурын хамгаалалт хийгээгүйгээс цаашид ажилбар явуулах боломжгүй болсон гэх мэт.

1.28 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлэх барилга байгууламжийг хэд хэдээр нь давхардуулан авсан, ажлын гүйцэтгэл нь хангалтгүй ААН-үүд байна. Тухайлбал,

- “Нийслэл-Өргөө” ХХК нь 3 объектод 30.5 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан,
- “Алтанбулаг трейд” ХХК нь 3 объектод 8.8 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан,
- “Бүтээл шинэ сонголт” ХХК нь 3 объектод 3.2 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан,
- Мөн нэр бүхий 15 ААН тус бүр 2 объектод 36.4 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан гэх мэт.

1.29 Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэх чадвар, хүчин чадал, хариуцлагаас шалтгаалж, ажил удааширч гэрээний хугацаанд төсөл, арга хэмжээг гүйцэтгэх боломжгүй байдалд хүргэж байна. Тухайлбал,

- Үе шатны ажлын графикийг батлуулаагүй болон мөрдөж ажиллаагүй 45,
- Тендерийн баримт бичигт заасан ажиллах хүчин болон инженер, техникийн ажилтнуудыг ажиллуулаагүй 15,
- Тендерийн баримт бичигт заасан машин механизм ашиглаагүй 6,
- Давхар ажил гүйцэтгэж буй 18,
- Чанаргүй болон зураг төсөвт заасан барилгын материал ашиглаагүй, материалын орц нормыг баримтлаагүй 14,
- Санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан, ажлын гүйцэтгэлийг хуурамчаар гаргасан 7,
- Батлагдсан зураг төсвийн дагуу ажиллаагүй, зураг төсвийг санаатайгаар

өөрчилсөн, барилгын норм дүрэм, технологийг баримтлаагүй 14 гүйцэтгэгч байна.

1.30 Захиалагч болон гүйцэтгэгч байгууллагууд батлагдсан зураг, төсвийг дур мэдэн өөрчилдөг, технологийн горим зөрчдөг, зураг, төсөвт дүгнэлт гаргаж буй байгууллагууд сайтар хянадаггүй, алдаа зөрчлийг илрүүлдэггүй нь тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлэх, гүйцэтгэл удаашрахад нөлөөлдөг нь илэрхий байна.

Барилга байгууламжийн байршил, хийц, талбайн хэмжээнээс шалтгаалан төсөвт өртөг харилцан адилгүй байна

1.31 Ижил төрлийн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг харилцан адилгүй, ам.метр талбайн үнэ ихээхэн зөрүүтэй байна.

Хүснэгт №9

Дүн шинжилгээнд хамрагдсан төсөл, арга хэмжээний					/сая төгрөг, м2/ Мөрдөж буй эрхийн актаар	
Барилга, байгууламжийн төрөл	Төсөвт өртгийн дүн	Нэгж талбайн дундаж өртөг		Нэг ор, суудалд ногдох өртөг	Нэгж талбайн төсөвт өртгийн жишиг ¹	Нэгж хүчин чадалд ногдох төсвийн жишиг ²
		Тэнхлэгээрх	Ашиг-тай			
Цэцэрлэгийн байр	893.7	1.16	1.37	8.75	0.84	4.25
Сургуулийн дотуур байр	1 151.9	1.11	1.38	10.92	0.64	4.35
Соёлын төвийн барилга	1 371.8	1.04	1.23	5.15	0.65	-
Театр, чуулгын барилга	8 639.5	0.98	1.18	13.89	0.75	-
Спорт заалтай сургууль	2 980.3	0.95	1.12	6.28	0.66	-
Сургуулийн барилга	2 677.6	0.80	1.00	5.23	0.63	1.71

1.32 Дэлгэрэнгүй тайлбарыг доорхи жишээнээс харна уу. Үүнд:

- **Цэцэрлэгийн барилгын хувьд:** Тэнхлэгээрх тооцсон нэгж талбайд ногдох төсөвт өртөг дунджаар 1.2 сая төгрөг байгаа ба хамгийн бага өртгөөр Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өртөгтөгөл 0.7 сая төгрөг, хамгийн өндөр өртгөөр Сүхбаатар аймгийн Асгат суманд баригдаж буй 100 ортой цэцэрлэгийн нэгж талбайн өртөг 3.6 сая төгрөг байна.

Эдгээрээс 20 цэцэрлэг дунджаас доогуур өртөгтэй баригдаж байгаа бол 17 барилга дунджаас дээш буюу 0.2-2.4 сая төгрөгөөр илүү, харилцан адилгүй үнэ өртөгтэй баригдаж байгааг харж болно.

Түүнчлэн төсөвт өртөгийн дунджыг бүс нутгийн байдлаар авч үзвэл нийслэлд 1.53, зүүн бүс 1.45, баруун бүс 1.31, төвийн бүс 1.07, хангайн бүс 1.0 сая төгрөг буюу орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нарийвчлан тооцох, жишиг өртгийг гаргах шаардлагатайг харуулж байна.

¹ ЗТБХБС-ын 2012 оны "Барилга угсралтын ажлын үнийн өсөлтийн 2011 оны индекс батлах тухай" 109 дүгээр тушаал

² Засгийн газрын 2010 оны "Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай" 336 дугаар тогтоол

- **Соёлын төвийн барилгын хувьд:** Тэнхлэгээрх тооцсон нэгж талбайд ногдох төсөвт өртөг дунджаар 1.4 сая төгрөг байгаа бол хамгийн бага өртөгтэй буюу Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын 250 суудалтай барилга 0.52 сая төгрөг, харин өндөр өртөгтэй буюу Өмнөговь аймгийн Баяндалай суманд баригдаж буй 200 суудалтай барилгын нэгж талбайн өртөг 1.71 сая төгрөг байна.
- **Дотуур байрны барилгын хувьд:** Тэнхлэгээрх тооцсон нэгж талбайд ногдох төсөвт өртөг дунджаар 1.11 сая төгрөг бол хамгийн бага өртөгөөр Хэнтий аймгийн Батноров сумын 50 ортой дотуур байр 0.44 сая төгрөг байхад хамгийн өндөр өртөгтэй Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 150 ортой дотуур байрны барилгын нэгж талбайн өртөг 2.39 сая төгрөгөөр зохиогдсон байна.
- **Спорт цогцолборын барилгын хувьд:** Дунджаар 1100 хүний суудалтай нийт 7 спорт цогцолборын барилгаас судалгаанд хамрагдсан 6 барилгын тэнхлэгээрх нэгж талбайд ногдох дундаж дундаж нь 1.76 сая төгрөг. Дундаж өртөгөөс дээш төсөвт өртөгтэй 2 доош төсөвт өртөгтэй 4 барилга байна.

1.33 Барилга байгууламжийн нэр төрлөөр болон тэнхлэгээрх талбай, нэгж талбайд ногдох төсөвт өртөгт хийсэн судалгааг тайланд хавсаргав.

Барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэл санхүүжилтээс зөрүүтэй байна

1.34 Гүйцэтгэгчийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлээ гарган санхүүжилт хүссэн хугацаанаас санхүүжилтийг олгосон хүртэлх хугацаанд судалгаа хийхэд нэгж санхүүжилтэд дунджаар 30 хүртэл, хамгийн их нь 120 орчим хоног зарцуулсан байна. Тухайлбал,

- Архангай аймгийн Багшийн коллежийн барилгын санхүүжилтийг 2009 онд олгоод, 2010 онд өгөөгүй алгассан,
- Говь-Алтай аймгийн Алтай чуулгын барилгын санхүүжилтийг 2010, 2011 онд санхүүжилтийг олгоогүй 2 жил завсардсан,
- Сэлэнгэ аймгийн Шаамар сумын соёлын төвийн барилгын санхүүжилт 72 хоног,
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд баригдаж буй усан бассейны санхүүжилт 116 хоног,
- Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Хөххөтөл багт баригдаж буй сургуулийн дотуур байрны барилгын санхүүжилт 120 хоног,
- Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгт баригдаж буй геронтологийн төвийн барилгын санхүүжилт 124 хоног,
- Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Үүрийн голын гүүрийн барилгын ажлын санхүүжилт 185 хоног,
- Булган аймгийн Сэлэнгэ сумын гүүрийн барилгын санхүүжилт 46-117 хоног,
- Дархан-Уул аймгийн спорт цогцолборын барилгын санхүүжилт 20-101 хоногийн дараа олгогджээ.

1.35 Түүнчлэн гүйцэтгэгчээс санхүүжилт хүссэн, захиалагчийн хяналт хийж санхүүжилтийн эрх хүссэн, Сангийн яамнаас хяналт хийж эрх нээсэн, төрийн сангаас гүйцэтгэгчид шилжүүлсэн дүн харилцан адилгүй хянагдаж, санхүүжилт олгогджээ. Тухайлбал,

- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төвийн шинэчлэл ажлын гүйцэтгэл 1,830.4 сая, захиалагчийн хяналт хийж санхүүжилт хүссэн 1,830.4 сая, Сангийн яамнаас

хяналт хийж эрх нээсэн 457.6 сая төгрөг,

- Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Үүрийн голын гүүрийн ажлын гүйцэтгэл 355.8 сая, захиалагч, Сангийн яамнаас 355.8 сая төгрөгөөр хянасан боловч төрийн сангаас 147.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон,
- Хэнтий аймгийн Биндэр сумын 640 суудалтай сургуулийн барилгын гүйцэтгэл 1,530.0 сая төгрөг байхад төрийн сангаас 1,188.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон,
- Хэнтий аймгийн Батноров сумын 150 ортой дотуур байрны барилгын гүйцэтгэл 1,016.1 сая төгрөг гарсан байхад 225.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон,
- Сүхбаатар аймгийн Асгат сумын 320 суудалтай сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 1,079.8 сая төгрөг байхад, захиалагчийн хяналт 812.3 сая, төрийн сангаас 797.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон,
- Өмнөговь аймгийн Бичигтийн боомтын гаалийн 8 айлын орон сууцны барилгын ажлын гүйцэтгэл 511.1 сая төгрөг байхад, олгосон санхүүжилт 38.8 сая төгрөгөөр өсч 549.9 сая төгрөг олгогдсон,
- Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 500 суудалтай соёлын төвийн барилгын гүйцэтгэл 2,901.4 сая, захиалагчийн хяналт хийгдсэн дүн 2,726.0 сая төгрөг бол Сангийн яам 2,114.5 сая төгрөгөөр тус тус хянасан байна.

1.36 Ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт ихээхэн зөрүүтэй байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

ТЭЗ	Төсөл, арга хэмжээний тоо	Гэрээний үнийн тоо	Олгосон санхүүжилт	Ажлын гүйцэтгэл		Санхүүжилт				Гэрээний дүнгээс илүү
				Захиалагч баталгаажуулсан	Бодит	Захиалагчийн баталгаажуулсан дүнгээс		Хөндлөнгийн шинжээчийн бодит гүйцэтгэлээс		
						Дутуу	Илүү	Дутуу	Илүү	
ШС	4	3 493.0	4 171.8	5 743.0	4 335.3	1 571.2		951.5	788.0	742.3
СС	3	2 552.9	915.3	932.6	936.1	418.1	400.8	451.8	431.0	
ХЗС	4	41 024.1	25 139.6	35 050.3	35 743.3	9 910.7		10 806.9	203.2	
БХБС	15	58 749.6	31 717.3	32 049.2	35 321.0	1 785.1	1 453.2	5 723.8	2 120.1	
БШУС	67	81 706.1	47 578.0	52 233.2	50 458.6	6 073.0	1 417.8	8 869.3	5 988.6	1 976.4
ЗТС	9	108 368.3	42 702.0	53 187.3	52 916.7	10 668.0	182.7	10 906.1	691.5	
ССАЖ С	22	57 978.4	42 848.3	44 300.6	43 526.4	2 210.5	758.3	3 962.7	3 284.6	325.9
ҮХААС	1	650.0	225.0	225.0	225.0					
ХС	1	600.0	390.0				390.0			
ЭМС	6	39 163.1	28 423.6	28 610.5	25 833.9	186.9		1 454.9		
ДҮН	132	394 285.5	224 110.9	252 317.7	249 296.3	32 823.5	4 602.8	43 127.0	13 507.0	3 044.6

1.37 Үүнээс үзэхэд гүйцэтгэгч байгууллага барилга угсралтын ажлын бодит гүйцэтгэлийг өсгөх, захиалагч болон Сангийн яамнаас бодит байдлыг бүрэн хянаагүй, санхүүжилт илүү дутуу хийгдэх тохиолдол нийтлэг байна. Санхүүжилтийг дутуу хийх, санхүүжилт хийх хугацааг удаашруулах зэрэг нь гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, ажлаа зогсоох шалтаг болдог байна.

Барилгын төсөв зохиох норм, норматив, барилгын үнэ бүрдэлтийн журмыг 2012 онд өөрчилж шинэчилсэн нь барилгын төсөвт өртгийг нэмэгдүүлсэн байна

1.38 Барилгын норм, норматив тогтоох, үнэ, төсөв бүрдүүлэх чиглэлээр хууль тогтоомжийн дараах эрх зүйн зохицуулалт үйлчилж байна. Тухайлбал:

Засгийн газрын бүрэн эрх:

- Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д "Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо, барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ, үнийн индексийг батлах, зарлах" гэсэн,
- Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т "Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавина" гэсэн,

Барилгын асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх:

- Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т "барилгын норм, дүрэм батлах, стандарт хянах, мөрдүүлэх" гэсэн заалттай байна.

1.39 Засгийн газар 2010 оны "Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ батлах тухай" 336 дугаар тогтоолыг Барилгын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7-д заасан бүрэн эрхийн дагуу гаргасан байна.

1.40 Уг тогтоолоор барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээг "... хөрөнгө оруулалтын төсөл боловсруулахад ашиглах"-аар тогтоосон байх бөгөөд "... барилгын материал, түүхий эд, хийц эдлэлийн зах зээлийн үнэ, авто тээвэр, машин механизмын үйлчилгээний тариф, ажилчдын цалин хөлсний өсөлттэй уялдуулан барилгын нэгж талбайн төсөвт өртөг, нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээнд хэрэглэх барилга угсралтын ажлын үнийн өсөлтийн индексийг Үндэсний статистикийн хороотой зөвшилцөн жил бүр баталж, нийтэд мэдээлж байх"-ыг ЗТБХБС-д үүрэг болгосон байна.

1.41 ЗТБХБС-ын 2012 оны 109 дүгээр тушаалаар "Барилга угсралтын ажлын үнийн өсөлтийн 2011 оны индексийг баталсан байна.

1.42 Барилгын төсөв зохиоход хэрэглэх "Зам, барилгын ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг"-ийг БХБС 2007 оны 210 дугаар тушаалаар шинэчлэн баталж, 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдүүлснээр барилгын төсвийн бүтэц дэх цалингийн зардлыг 1.9 дахин нэмэгдүүлсэн байна.

1.43 Мөн энэ тушаалаар төсөв зохиох журам, аргачлалын дагуу цалингаас тодорхой итгэлцүүрээр тооцдог зардлууд болох "бусад шууд зардал", "нэмэгдэл зардал", "төлөвлөгөөт хуримтлал"-ыг шинэчилсэн тарифт цалингийн жишгийг 0.52 гэсэн итгэлцүүрээр бууруулан хэрэглэж байхаар шийдвэрлэсэн нь цалингийн өсөлтийг дагаж гарах эдгээр зардлуудын өсөлтийг дээрх итгэлцүүрийн дагуу бууруулах хязгаарлалт болсон байна. .

1.44 Түүнчлэн барилгын төсөв зохиоход хэрэглэх "Зам, барилгын ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг"-ийг ЗТБХБС-ын 2009 оны 263 дугаар тушаалаар дахин шинэчлэн баталсны дүнд барилгын төсвийн бүтэц дэх цалингийн зардлыг тухай үед байсан түвшингээс 2 дахин нэмэгдүүлжээ. Ингэхдээ дээр дурдсан 0.52-ыг 0.26 болгож бууруулахаар шийдвэрлэсэн байна.

1.45 ЗТБХБС 2012 онд "Барилгын дүрмүүд батлах тухай" 18 дугаар, "Барилгын норм ба дүрэм батлах тухай" 181 дүгээр тушаалуудыг тус тус баталсан байна.

1.46 Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар "Барилгын машин ашиглалтын нэг машин цагийн жишиг үнэ тодорхойлох аргачлал", "Барилгын технологийн тээврийн автомашины цагийн болон тонн километрийн жишиг үнэ"-ийг өөрчлөн баталсны дүнд барилгын төсөвт өртгийн бүтэц дэх "машин механизм"-ын зардал 4 дахин өссөн байна.

1.47 Мөн тушаалаар дээр дурдсан 0.26 гэсэн итгэлцүүрийг хүчингүй болгосон байна. Ингэснээр барилгын төсөвт өртгийн бүтэц дэх цалингаас тодорхой итгэлцүүлээр тооцдог зардлууд болох "бусад шууд зардал", "нэмэгдэл зардал", "төлөвлөгөөт ашиг" зэрэг зардлуудын төсөв 3.8 дахин нэмэгдэх болсон байна.

1.48 ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар барилгын төсөв зохиох норм, нормативт орсон дээрх өөрчлөлтүүдийн дүнд барилгын төсөвт өртөг нийт дүнгээрээ 2012 оныхоос 40 гаруй хувиар өсөх нөхцөл бүрдсэн байна.

1.49 Барилгын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2012 онд гаргасан ЗТБХБС-ын "Барилгын норм ба дүрэм батлах тухай" 181 дүгээр тушаалаар "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм", "Барилгын төсөв зохиох дүрэм"-ийг шинээр баталж, 2012 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхээр шийдвэрлэсэн байна.

1.50 Энэ тушаалаар батлагдсан шинэ журмын дагуу барилгын төсөвт өртгийг тооцох аргачлал, журам нормчлолд хэд хэдэн зарчмын өөрчлөлт оруулжээ. Тухайлбал, барилгын төсвийн бүтцэд цалингийн 58.4 хувиар тооцож оруулдаг байсан "Бусад шууд зардал" гэсэн зардлыг байхгүй болгож, оронд нь "талбайн инженер техникийн ажилчдын цалин", "нэмэгдэл цалин", "ажлын багаж, хувцас хэрэгслэл" гэсэн зардлын шинэ төрлүүд бий болгож, "Төлөвлөгөөт ашиг"-ийг цалингийн зардлаас 95 хувиар тооцдог байсныг өөрчлөн шууд зардлын дүнгээс 15.0 хувиар тооцдог болгосон байна.

1.51 Дээрх тушаалаар орсон өөрчлөлтүүдийн дүнд барилгын төсөвт өртөг ойролцоогоор 11.0 хувиар нэмэгдэх нөхцөл бүрдсэн гэж мэргэжилтнүүд тооцоолсон байна.

1.52 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орсон барилга, объектын төсөвт өртгийг өсгөж, төсвөөс нэмэлт эх үүсвэр шаардагдах үр дагавартай дээрх тушаалуудыг гаргахдаа Сангийн яамтай зөвшилцөх, улмаар Засгийн газарт танилцуулах үйл ажиллагаа хийгдээгүй, төсвийн норм нормативуудыг тогтоохдоо Засгийн газрын 2012 оны 336 дугаар тогтоолоор баталсан барилгын нэгж талбайн төсөвт өртгийг чиг баримжаа болгон харгалзаж үзээгүй байна.

1.53 Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "санхүү, төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д "төсвийн жилийн дундуур орлого

бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх"-аар заасан байна.

1.54 ЗТБХБС-ын 2012 оны 181 дүгээр тушаалд мөрдөх хугацааг мөн оны 9 дүгээр сарын 1-нээс хэрэгжихээр тогтоосон нь хуулийн дээрх заалттай зөрчилдсөн, 18 дугаар тушаал нь Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-д заасан шаардлагыг хангаагүй байна.

Дүгнэлт:

Дүн шинжилгээний аудитаар хэрэгжүүлсэн арга зүй, горим, судалгааны дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Нэг. Дүн шинжилгээнд хамрагдсан төсөл, арга хэмжээг цаашид хэрэгжүүлэх талаар:

- 1.1 Дүн шинжилгээнд хамрагдсан 272 төсөл, арга хэмжээнээс 518.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 146 төсөл, арга хэмжээ 2014 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгаж хэрэгжүүлэх боломжтой. Үүнээс 79.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 37 объект 2014 онд ашиглалтад орох боломжтой байна.
- 1.2 Улсын Их хурлын 2013 оны 63 дугаар тогтоолын 1.5 дахь заалтын дагуу санхүүжилтийн эх үүсвэрийг Хөгжлийн банкаар дамжуулан шийдвэрлэх шаардлагатай 121.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий зам, гүүрийн 15 төсөл, арга хэмжээ байна.
- 1.3 Төсвийн болон Барилгын тухай хуульд заасан шаардлагыг хангаж зураг төсөв, техникийн нөхцөл бэлэн болгосны үндсэн дээр 2015 оны төсвийн тухай хуульд тусгах боломжтой 81 төсөл, арга хэмжээ байна.
- 1.4 Дүн шинжилгээнд хамрагдсан төсөл, арга хэмжээнд улсын төсвөөс санхүүжилт төлөвлөх шаардлагагүй нийт 24.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 23 объект байна.
- 1.5 Дүн шинжилгээнд хамрагдсан төсөл, арга хэмжээнээс 58.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 объектын зориулалтыг өөрчилж, худалдах замаар улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийг нөхөн төвлөрүүлэх асуудлыг судалж, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх шаардлагатай.
- 1.6 Техникийн нөхцлөөс шалтгаалан Хан-Уул дүүргийн 300 ортой 4 дүгээр төрөх 2014 онд ашиглалтад орох боломжгүй нөхцөл байдал үүссэн учраас 2014 оны төсөвт 3 дугаар төрөхийн барилга угсралтын ажлын үлдэгдэл санхүүжилтийг төлөвлөж ашиглалтад оруулах нь зүйтэй.
- 1.7 Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн харъяа Түлэнхийн төвийн барилгын зураг төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг хянаж дахин боловсруулсны үндсэн дээр Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн барилгын өргөтгөл хэлбэрээр шийдвэрлэх боломжийг судлах, одоогийн байршил дээр хүүхдийн эмнэлэг барих ТЭЗҮ, зургийн даалгавар боловсруулах нь зүйтэй.

Хоёр. Гүйцэтгэл удааширсан, төсөвт өртөг нэмэгдсэн шалтгаан, цаашид авах арга хэмжээний талаар:

- 2.1 Хөрөнгө оруулалтыг төлөвлөх, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хянаж баталгаажуулах, техникийн нөхцөл хангах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, барилга объектыг барьж ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих зэрэг хөрөнгө оруулалтыг эзэмших бүх үе шатанд нэгдсэн бодлого зохицуулалтгүй, мөрдөж буй хууль, журам, стандартууд уялдаа холбоогүй байгаагийн зэрэгцээ захиалагч, гүйцэтгэгч, зураг төсвийн болон холбогдох мэргэжлийн байгууллагууд, төрийн албан хаагчдын ажил хариуцах чадвар, хариуцлага сул, хууль журам мөрддөггүй, хяналт тавьж хариуцлага тооцдоггүй байдал давамгайлж ужгирсан нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удаашрах үндсэн шалтгаан болж байна.
- 2.2 Дүн шинжилгээний аудитын дүнд илэрч бүртгэгдсэн хууль, журам, гэрээний зөрчлүүд нь ажил хариуцсан төрийн албан хаагчид, байгууллагуудын санаачилга, мэргэжлийн ур чадвар, гүйцэтгэлийн сахилга бат, хариуцлагатай холбоотой учир Засгийн газар тодорхой дүгнэлт хийж холбогдох арга хэмжээ авах шаардлагатай.
- 2.3 Хуульд заасан шаардлагыг хангаагүй объектыг төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгаснаас зураг төсвийг боловсруулах, баталгаажуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зэрэг үйл ажиллагаанд бүтээн байгуулалтын хугацааны бараг тэн хагасыг зарцуулж байгаа нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хуульд заасан хугацааг хойшлуулахад хүргэж байна.
- 2.4 Барилгын төсвийн, гэрээний болон санхүүжилтийн тогтолцоонд барилга объектийг хуульд заасан хугацаанд нь төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүйгээр барьж дуусгахыг урамшуулсан хөшүүрэг, зохицуулалт, үнэлгээ, хариуцлагын механизм байхгүй нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэх хугацаа удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх нөхцлийг бүрдүүлж байна.
- 2.5 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хуульд заасан хугацаа удааширч байгаа нь төсөвт өртөг нэмэгдэх нэг гол шалтгаан болж байна. Иймд хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх, ялангуяа ашиглалтад оруулах хугацааг зөв тооцоолж, оновчтой төлөвлөх, гүйцэтгэлийн сахилга батыг чандлах чиглэлээр хууль эрх зүйн зохицуулалт, арга зүй, зохион байгуулалтын шинэчлэл хийх шаардлагатай болсон байна.
- 2.6 Төсөл, арга хэмжээний зургийн даалгавар, зураг төсөл, төсөвт өртгийг алдаатай тооцоолж дутуу боловсруулах, нэмэгдэл зураг төсөв зохиох, тэдгээрт дур зоргоороо өөрчлөлт оруулах замаар төсөвт өртгийг нэмэгдүүлж дараа оны төсвийн тухай хуульд тусгуулах жишиг тогтсон байна.
- 2.7 Түүнчлэн тендерт бага үнээр ялж, гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангаж зохион байгуулах шатанд захиалагчийн хяналтыг сулруулж, захиалагч, гүйцэтгэгч,

зураг төсөв зохиогч, баталгаажуулагч байгууллагууд хамтран төсөвт өртгийг нэмэгдүүлдэг, зарим тохиолдолд гүйцэтгээгүй ажлыг баталгаажуулж санхүүжилт олгодог явдал байна. Барилгын төсөвт өртгийг нэмэгдүүлдэг эдгээр зохисгүй үзэгдлийг таслан зогсоох шаардлагатай.

- 2.8 Засгийн газрын 2010 оны 336, 2012 оны 109 дүгээр тогтоол, БХБС-ын 2007 оны 210, ЗТБХБС-ын 2012 оны 263, 18, 181 дүгээр тушаалуудаар барилгын төсөвт өртгийг нэмэгдүүлэх шийдвэр гарч хэрэгжсэн нь төсөл, арга хэмжээний төсөвт өртөг их хэмжээгээр нэмэгдэх бас нэг гол шалтгаан болсон байна.
- 2.9 Үүний дотор, ЗТБХБС-ын 2012 оны 18, 181 дүгээр тушаалаар батлагдсан шийдвэрүүд нь 2013 оноос эхлэн барилга объектын төсөвт өртгийг ихээхэн хэмжээгээр өсгөж, цаашид улсын төсвийн ачааллыг нэмэгдүүлэхээр байгаа тул дээрх тушаалуудыг Засгийн газрын түвшинд хянан үзэж, оновчтой шийдвэр гаргах шаардлагатай гэж үзэж байна.
- 2.10 Мөн ЗТБХБС-ын 2012 оны 181 дүгээр тушаалаар баталсан "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм", "Барилгын төсөв зохиох дүрэм", түүнчлэн барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээний зохицуулалт болон санхүүжүүлэх, хяналт тавих журмыг барилга объектийг хуульд заасан хугацаанд нь төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүйгээр барьж дуусгахыг урамшуулсан эдийн засгийн хөшүүрэг, зохицуулалт, үнэлгээ хариуцлагын механизм бий болгох чиглэлээр шинэчлэн боловсруулж хуулийн зохицуулалтын түвшинд шийдвэрлэх шаардлагатай байна.

ХОЙШЛУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

Дэд арга хэмжээний дугаар	Хуульд тусгагдсан код	Төсөл, арга хэмжээний нэр	ТЕЗ	Байршил		Гэрээний		код	3.1	3.2	3.3	3.4
				Аймаг, нийслэл	Гүйцэтгэгч компани	Анхны			Хойшлуулах			
						Огноо	Мөнгөн дүн		Хуульд нийцүүлээд дахин төлөвлөх	Дэд бүтцийн асуудлыг шийдсэний дараа үргэлжлүүлэх	Хэрэгцээ шаардлагыг харгалзан дахин төлөвлөх	Цаашид ашиглах боломжтой эсэхэд дүнлэлт гаргуулах
1	XIII.3.1.1	Шалган нэвтрүүлэх цогцолбор /Увс, Давст сум, Боршоо боомт/	СС	Увс	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
2	XIV.5.1.1	Үндэсний төв архивын нэгдсэн байрны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	ХЗС	УБ	Нийслэл Өргөө ХК	2010.08.27	7 721,0	3.2		1		
3	XV.1.33	Шинээр барилгын материалын лаборатори байгуулах /Дорноговь, Дорнод, Өмнөговь, Ховд, Орхон/	БХБС	Өмнөговь				3.3			1	
4			БХБС	УБ				3.1	1			
5	XV.1.45	Аймаг нийслэлийн бүсийн тулгуур төвүүдэд барилгын материалын жижиг дунд үйлдвэр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж барилгын материалын иж бүрэн лаборатори байгуулах	БХБС	УБ				3.1	1			
6	XV.1.46	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх /орон нутагт/	БХБС	Дорноговь	Фронт гейт ХХК	2013.06.06	5 844,1	3.5				1
7	XV.1.48	"ХХI зуун" хорооллын гадна цэвэр бохир ус, дулаан, холбоо цахилгааны шугам сүлжээний барилга угсралтын ажил /Завхан, Улиастай сум/	БХБС	Завхан	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
8	XV.3.33	Улаанбаатар хотын барилгын материалын төв лабораторийн тоног төхөөрөмж	БХБС	УБ	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
9	XVII.1.1.28	Дэлхийн банкны "Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл" төслийн Монголын талын хөрөнгө	БШУС	УБ	Экс инженеринг ХХК	2012.12.30	961,9	3.1	1			
10				Сэлэнгэ	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
11	XVII.1.1.42	Сургуулийн дотуур байрны барилга, 150 ор /Дархан-Уул, Шарын гол сум/	БШУС	Дархан-Уул	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
12	XVII.1.1.46	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сэлэнгэ, Мандал сум/	БШУС	Сэлэнгэ	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
13	XVII.1.1.48	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Эрдэнэбулган, 2 дугаар цэцэрлэг/	БШУС	Архангай	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
14	XVII.1.1.49	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон/	БШУС	Сэлэнгэ	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
15	XVII.1.1.50	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн сум, 6 дугаар баг/	БШУС	Дорнод	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
16	XVII.1.1.51	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Өмнөговь, Цогт-Овоо сум/	БШУС	Өмнөговь	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
17	XVII.1.1.52	Сургуулийн өргөтгөл, шинэчлэлт /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 6 дугаар сургууль/	БШУС	Сэлэнгэ	Комп трэйд ХХК	2013.11.08	486,2	3.3			1	
18	XVII.1.1.56	Сургуулийн дотуур байрны барилга, 80 ор /Өмнөговь, Хүрмэн сум/	БШУС	Өмнөговь	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
19	XVII.1.1.62	Сургуулийн барилга, 640 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Эрдэнэ баг/	БШУС	Орхон	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
20	XVII.1.1.65	Сургуулийн барилга, 320 суудал /Дундговь, Дэлгэрхангай сум/	БШУС	Дундговь	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
21	XVII.1.1.68	Дотуур байрны барилга, 80 ор /Хэнтий, Баянмөнх сум/	БШУС	Хэнтий	Хөлөг од ХХК	2013.08.19	500,0	3.4				1
22	XVII.1.1.71	Цэцэрлэгийн барилга, 150 ор / Дорнод, Баян-Уул сум/	БШУС	Дорнод	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
23	XVII.1.1.72	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Дундговь, Луус сум/	БШУС	Дундговь	Гүйцэтгэгч шалгараагүй	Гэрээ байгуулагдаагүй		3.3			1	
24	XVII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сүхбаатар, Мөнххаан сум/	БШУС	Сүхбаатар	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
25	XVII.1.1.95	Дотуур байрны барилга, 120 ор /Дорнод, Баяндун сум/	БШУС	Дорнод	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
26	XVII.1.1.96	Сургуулийн спорт заалны барилга /Хөвсгөл, Мөрөн, 2 дугаар сургууль/	БШУС	Хөвсгөл	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	

27	XVII.1.1.97	Дотуур байрны барилга 100 ор /Хөвсгөл, Цагааннуур сум/	БШУС	Хөвсгөл	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
28	XVII.1.1.98	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Дорнод, Хэрлэн, 11 дүгээр цэцэрлэг/	БШУС	Дорнод	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
29	XVII.1.1.100	Спорт заалны барилга /Дундговь, Сайнцагаан, "Говийн ирээдүй" цогцолбор сургууль/	БШУС	Дундговь	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
30	XVII.1.1.101	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Сүхбаатар, Асгат сум/	БШУС	Сүхбаатар	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
31	XVII.1.1.104	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Говьсүмбэр, Сүмбэр, 1 дүгээр цэцэрлэг/	БШУС	Говьсүмбэр	Оточ ноёд ХХК	2013.08.20	1 001,4	3.4				1
32	XVII.1.1.107	Дотуур байрны барилга, 100 ор /Дундговь, Өндөршил сум/	БШУС	Дундговь	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
33	XVII.1.1.108	Дотуур байрны барилга, 120 ор /Төв, Батсүмбэр сум/	БШУС	Төв	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
34	XVII.1.1.109	Дотуур байрны барилга, 150 ор /Улаанбаатар, Сүхбаатар, 25 дугаар тусгай сургууль/	БШУС	УБ	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
35	XVII.1.1.110	Спорт заалны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 60 дугаар сургууль/	БШУС	УБ	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
36	XVII.1.1.112	Сургуулийн дотуур байрны барилга /Баян-Өлгий, Улаанхус сум, Согор баг/	БШУС	Баян-Өлгий	Гэрээ байгуулагдаагүй			3.3			1	
37	XVII.1.1.114	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр сургууль/	БШУС	УБ	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
38	XVII.1.1.115	Цэцэрлэгийн барилга, /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	БШУС	УБ	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
39	XVII.1.1.118	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Лаборатори сургууль/	БШУС	УБ	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
40	XVII.1.1.119	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 104 дүгээр сургууль/	БШУС	УБ	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
41	XVII.1.1.120	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 8 дугаар хороо/	БШУС	УБ	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
42	XVII.1.1.121	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо/	БШУС	УБ	Гэрээ байгуулагдаагүй			3.1	1			
